

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР /ДАВАА  
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Хэлэлцсэн асуудал</b>	<b>Хуудасны дугаар</b>
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-6
	1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	3-6

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 28-ны өдөр  
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 00 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: С.Амарсайхан, Б.Дэлгэрсайхан, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Сэргэлэн, Н.Учрал.*

***Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Д.Мөнхтуяа, Д.Эрдэнэбалсүрэн, Ц.Цогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн багш О.Мөнхсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн авсан завсарлагын хугацааг 3 хоногоор сунгах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав. /14:05/

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ш.Адъяаа, С.Бямбацогт нар үг хэлэв.

*Хуралдаан 16 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 16 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР /ДАВАА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**С.Бямбацогт:** Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Дашдондогийн Ганбат гишүүн хүрэлцэн ирсэн байна, Ширнэнбаньдын Адьшаа гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн хүрэлцэн ирсэн байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн хүрэлцэн ирсэн байна, Баттөмөрийн Энхбаяр гишүүн хүрэлцэн ирсэн байна, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн хүрэлцэн ирсэн байна, Дамдины Цогтбаатар гишүүн хүрэлцэн ирсэн байна, Цэндийн Мөнх-Оргил гишүүн хүрэлцэн ирсэн байна, Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн хүрэлцэн ирсэн байна, Хишгээгийн Нямбаатар гишүүн хүрэлцэн ирсэн байна. Учрал гишүүн өвчтэй, Сэргэлэн гишүүн өвчтэй, Раднаасэд гишүүн чөлөөтэй, Амарсайхан гишүүн, Сандаг-Очир гишүүд тойрогтоо байгаа. Бусад гишүүдийг хуралдаандаа хүрэлцэн ирэхийг хүсэж байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. Нэг асуудалтай.

**Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.**

Засгийн газар 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн ийм асуудал байгаа. Түрүүчийн 7 хоногт хэлэлцэж байгаад Ардчилсан намын бүлэг завсарлага авсан байгаа. Завсарлагын хугацаа дууссан.

Хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүн байна уу? Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Гишүүдийнхээ амар амгаланг айлтгая. Өнөөдөр ингээд манай авсан завсарлага дуусаж байна. Уул нь Монгол Улсын шүүхийн тухай хууль маань ард иргэдийн нэлээн хүлээлт үүсгэсэн ийм хууль байгаа. Гэхдээ одоо яагаад ч юм бэ, ингээд ярьж барьсаар байгаад энэ хууль маань оны эцэс рүү тунардаг ч юм уу, санаатай ч юм уу, санамсаргүй байдалтай ийм болчхоод байгаа юм. Тэгээд иргэд бид нарыг бас шүүмжилдэг. Хуулийг түргэн, түүхий хэлэлцээд гаргачихдаг. Энэ хууль маань тэгээд тогтворгүй, насгүй явж байгаад тэгээд нэг, хоёр жилийн дараа өөрчлөгдөөд ингээд явдаг. Энэ хууль дээр тэгж болмооргүй байгаа юм. Тэгээд өмнө нь Хууль зүйн байнгын хороон дээр Ардчилсан нам бол тав хоногийн завсарлага авах эрхтэй. Хуралдаан даргалагч гурав хоногийн завсарлага өөрийнхөө үзэмжээр өгөх эрхтэй. Энийгээ өгсөн.

Ингээд одоо бас баярын өмнө, өнөөдрийн ирц ч гэсэн 52.6 хувьтай байна. 13 цагт эхлэх ёстой хурал маань ингээд 14 цаг өнгөрөөгөөд эхэлж байна. Ер нь аль аль талаараа, гишүүдийнхээ ирцийг сайн оролцуулах, идэвх санаачилгыг байлгах, мөн шинэ оны өмнө энэ хуулийг ингээд Байнгын хороогоор хэлэлцээд яриад байх нь, зовлонтой энэ үед нэг их зохисгүй байх аа. Тийм учраас, ер нь ингээд харж байхад Улсын Их Хурлын гишүүн, бид бүхний ажлын хэсэг байгуулаад

ажиллаж байхад энэ Засгийн газрын оруулж ирсэн хууль дээр 39 зүйл, 223 хэсэг заалтыг өөрчилж, 100 гаруй хэсэг заалтыг шинээр нэмэх, зарчмын зөрүүтэй 70 гаруй санал орж ирж байна, бэлдчихсэн байна гэдэг энэ зүйл нь Засгийн газраас орж ирсэн хууль маань нэлээн түүхий хууль байсан байна. Энэ дээр ажлын хэсэг, Улсын Их Хурал нэлээн сайн ажиллаж, ийм олон зүйл, заалтыг оруулахаар бэлтгэсэн байна. Ингээд энэ зүйлийг бас илүү харж үзэж ажиллах шаардлагатай байна гээд Ардчилсан намын бүлэг үзэж байна.

Ингээд Ардчилсан намын бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлаар авсан завсарлагын хугацаагаа 3 хоногоор сунгаж завсарлага авахыг хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ганбат гишүүний, Ардчилсан намын бүлгийн гаргаж байгаа саналыг бас хүндэтгэж үзэж байна. Гэхдээ түрүүн хэлж байгаа нь, Шинэ жил рүү дөхчихлөө гэдэг бол бас л энэ ажлын хэсгийн юм уу, Байнгын хороотой холбоотой асуудал биш шүү дээ. Ерөнхийлөгч бас нэг санал өгчихсөн, тэрнээс болж хойшилсон. Дараа нь та хэд маань бас 3 хоногийн завсарлага аваад, одоо ингээд дахиад завсарлага авчихаар шинэ он болоод. Одоо энийг чинь ингээд авчихаар он гарах нь л дээ. Тэгэхээр би юунд санаа зовж байна вэ гэхээр Их Хурлын маань зорилго бол шүүхийн реформыг хийх тухай асуудлууд байж байгаа, дараа дараачийн ажлууд бас үүсэж байгаа. Тэгэхээр он гараад ингээд ярьдаг, дахиад Цагаан сар ойртчихлоо. Одоо бас зориуд Цагаан сар ойртууллаа, тэгээд ингээд цаашаа баярууд юм уу, сонгуультай ч юм уу ингээд холбоод байх юм бол, би бас энэнд санаа зовоод байгаа байхгүй юу. Тэгээд дээр нь ер нь энэ сулрах вий дээ.

Одоо энэ Шүүхийн тухай хууль дээр ажлын хэсэг дээр бас ойлголцолд хүрээд наана, цаанатай ойлголцоод л явж байгаа. Тэгээд улам л барьцаа ахиулаад ил, далд хүмүүс яваад ингээд үргэлжлүүлээд байх юм. Би Улсын Их Хурлын гишүүний хувьд санаа зовж байна. Энэ хуулийн төсөл маань эрч нь суларсаар байгаад тэгээд энд, тэндэхийнх нь лобби орсоор байгаад сүүлдээ нөгөө тавьсан зорилгынхоо 50 хувьд хүрэх юм уу, үгүй юм уу. Сүржин эхлээд даржин дуусаж байгаа юм шиг болчих вий дээ. Тэгээд энэнд нь ямар нэгэн байдлаар бид нар өөрсдөө татагдан орчих вий дээ. Үндсэн зорилго, зарчмаа барьж байж юм зөв явдаг. Хугацаа хойшилж байгаад би санаа зовж байна. Тийм учраас энэ хугацааг татаж, бид нар бас баяр ёслол, КОВИД гэж яриад байж болохгүй шүү дээ.

Монгол Улсын Их Хурал бол тасралтгүй байнга ажиллах ёстой. Ганбат гишүүний дэмжээд байгааг ойлгож байна. Гэхдээ бид нар юманд, парламентын том хийгдэж байгаа ажил нь сая нэгжийн хууль гарчихлаа. Одоо Шүүхийн хуулийг харж байна. Энэ бол бидний шалгалт шүү дээ. Энэ удаагийн Улсын Их Хуралд орж ирсэн гишүүд, бүлгүүд ер нь цаашдаа хамтраад Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийнхөө бодлогыг яг аваад явж чадах юм уу, үгүй юм уу? Энд тэндэхийн лоббид ороод, энд тэндээсээ татаж чангаалгасаар байгаад тэгээд нэг сулхан хууль хийсэн нэртэй болчих вий дээ гэж. Энэнд л санаа зовж байна. Энийгээ бас хаана хаанаа бодоосой. Энэ лобби чинь бол ихсээд л байгаа шүү дээ. Тэгээд гишүүн болгоны санааг арай гэж бид нар боож, боож энэ хэмжээнд аваачиж байна. Цаашаа буулт хийж болохгүй, чадахгүй гэж бодож байгаа. Ингэх

юм бол энэ хуулийг хийсний хэрэг байхгүй. Ийм ажиллагаанд оролцоод явах вий дээ, хугацаа хойшлох тусам. Би бол зүгээр илэн далангүй л хэлж байгаа юм. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Баярлалаа. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн завсарлага авах тэр бүрэн эрхэд хүндэтгэлтэй хандаж байна. Гэхдээ бас сая Сүхбаатар гишүүний хэлээд байгаа асуудлыг та хэд маань ойлгооч ээ. Ер нь энэ чинь парламентын гал тогоонд орж ирээд нэлээн удчихлаа. 4 сард орж ирсэн, 8 сар болж байна. Шинэ парламент байгуулагдаад 8 сард Улсын Их Хурлын ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг сүүлийн хоёр сар амралтын өдөргүйгээр ажиллаж, сая Ганбат даргын хэлсэнчлэн 75 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг өнөөдөр та бүхэнд бас бэлтгээд хэлэлцэх гээд байж байгаа. Цаад мөн чанар бол Монгол Улсынхаа Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн энэ салбарт шударга ёсыг, хууль ёсыг тогтоох, Монгол Улсын иргэдийнхээ Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх тэр үндсэн эрхийг л бид баталгаажуулах эцсийн амин сүнс, зорилго байгаа. Энэ дээрээ бол хууль тогтоогчид маань нам үл харгалзан байгаа. Сүүлийн гурван 7 хоногийн өмнө ажлын хэсгийн ахлагчийн хувьд Ардчилсан намын бүлэгт Шүүхийн тухай хуулийн асуудлаар мэдээлэл хийж, Ардчилсан намын бүлгийн гишүүдийн асуултад хариулж өгсөн. Тодорхой нээлттэй дэлгэрэнгүй ийм асуулт хариулт, ийм ажил хэрэгч уур амьсгалтай болсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч мөн үүний дараа ажлын хэсгийн гишүүд, ахлагчтай уулзах ёстой. Тэгээд 37 хуудас, нийтдээ 100 санал ирүүлсэн. Ажлын хэсэг төрийн тэргүүний энэ байр суурьд хүндэтгэлтэй хандаж нэг бүрчлэн авч хэлэлцсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн саналын 98 хувь нь ажлын хэсгийн хүрээнд яригдаж туссан. Дараа нь Ардчилсан намын бүлэг маань завсарлага авсан. Энэ хугацаанд бас судалж байна гэдэг юм чинь яг юун дээр вэ гэдэг асуудлаа бид энэ хэлэлцүүлгийнхээ шатанд яриад явах боломжтой шүү дээ. Зарчмын зөрүүтэй байр сууриудаа хэлэлцүүлгийн шатанд асуултаа асуугаад, хариулаад, саналаа гаргаад шийдэх боломжтой. Энэ дээр та хэд маань бас нэг бодооч ээ. Дургүйд хүчгүй гэдэг шиг. Яг энэ шинэчлэлийг бол хийчихмээр л байгаа юм. Энэ бол бидний ард түмэн өгсөн хариуцлага байгаа юм. Хүч сулрахгүй л дээ. Хугацаа авагдлаа гээд лоббинд өртөхгүй. Хүч бол сулрахгүй. Энэ Үндсэн хуулиа бид амилуулах ёстой. Тийм учраас Улсын Их Хурал өөрөө тасралтгүй ингэж ажиллаж асуудлаа шийдэж авах талаасаа та хэд маань саналаа дахиж бодох ийм бололцоо байхгүй юу гэж одоо хүсэх гээд байгаа юм.

**С.Бямбацогт:** Сая ажлын хэсгийн ахлагч тодорхой хэллээ шүү дээ. Ардчилсан намын бүлгийн мэдээлэх гээд 7 хоног хүлээсэн, Ерөнхийлөгчид танилцуулах гээд 7 хоног хүлээсэн, завсарлага аваад 7 хоног. Одоо дахиад 3 хоног завсарлага авах юм бол ирэх 7 хоног руу орох гээд байна л даа. Үндсэндээ бүтэн сар энэ Улсын Их Хурал цөөнхөө хүлээгээд энэ хууль явахгүй, 1 сар гаруй болох гээд байна л даа. Тэгэхээр 3 хоног биш 2 хоногийн завсарлага авч болохгүй юу? 1 дэх өдөр бид нар зориуд Шүүхийн тухай хууль хэлэлцэх гэж тов тогтоосон. 3 дахь өдөр Хууль зүйн байнгын хороо дахиж хуралдахаар байгаа. 3 дахийн Байнгын хороогоор бид нар энэ асуудлаа хэлэлцээд явчихъя. 3 дахь өдрийн Байнгын хороо хүртэл завсарлагаа 3 хоног биш, нааш нь тавиад явчихаж болохгүй юу? Ондоо багтаад анхны хэлэлцүүлгийг хийчихмээр байна л даа. Анхны хэлэлцүүлэг хийсний дараа Их Хурал дээр та бүхэн бас ярьж болно шүү дээ, тийм ээ? Чуулганы явцад. Адьшаа гишүүн.

**Ш.Адьяшаа:** Гишүүдийнхээ горимын саналыг хүндэтгэж байна. Энэ хуулийг батлахгүй гэж Ардчилсан намын бүлэг ерөөсөө үзэхгүй байгаа шүү дээ. Энийг харин дэмжиж байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу энэ хуулийг батлах ёстой. Гэхдээ Засгийн газраас өргөн мэдүүлсэн тэр хуулийн чинь үзэл баримтлалын 70 гаруй хувьд нь өөрчлөлт орсон шүү дээ. Энэ их олон өөрчлөлт орсон. Дээр нь одоо энэ өөрчлөлт орсноосоо хойш иргэд тухайн мэргэжлийн байгууллагууд, олон түмэнд энийг нэгийг ч хэлэлцүүлэх арга хэмжээ зохион байгуулаагүй. Энийгээ бас хаана хаанаа яриад, заавал оны урд батлахаар сайхан болдог, оны дараа болохоор муухай болдог юм гэж байхгүй ээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд цөөнхийнхөө саналыг хүндэтгэж олон талаасаа ярилцаж шийднэ л гэсэн байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 9.2-т зааснаар өнөөдөр нам, эвслийн бүлэг хуралддаг өдөр шийдвэр гаргаад та нар хуралдаж байгаа. Энийг бид хүлээн зөвшөөрсөн, нэгэнт олонх ингэж шийдэж байгаа бол энэний дагуу гээд. Тэр дагуу бид Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дэгийн дагуу л завсарлагаа авъя гэж байгаа юм. Уул нь 5 хоног өгөх ёстой. Тэгээд 5 хоногоо дахиад сунгаад явах ийм зарчим байгаа шүү дээ, хууль дээр. Тийм учраас та нар одоо хуульд заасан завсарлагаа өгөх, өгөхгүй нь та нарын асуудал. Тэгэхдээ олонхынхоо энэ байдлаар битгий ингэж асуудалд хандаач ээ. Энд цөөнхийнхөө үгийг сонсооч ээ. Энэ хуулийн үзэл баримтлалтай танилцах, бид бас эрдэмтэн мэргэд, тухайн хуулийн талаар мэргэжлийн байгууллагатай санал бодлоо солилцох тийм боломжоор л хангаж өгөөч гэж ийм хүсэлт гаргасан юм. Ингээд Бямбацогт дарга аа, та бас энд зөв шийдвэр гаргах байх аа гэдэгт найдаж байна.

**С.Бямбацогт:** Шүүхийн тухай хуулийг өнгөрсөн 2020 оны 4 сард бид нар хэлэлцэн шийдсэн. Ерөнхийлөгчөөс Шүүхийн багц хуулиуд өргөн барьсантай холбоотойгоор Ерөнхийлөгчийн санаачилсан хуулиудыг хэрхэн яаж шийдэх вэ гэдэг нь хүлээгдсээр байгаад үндсэндээ 10, 11 сарын дунд хүртэл хүлээгдсэн. Тэр болтол ажлын хэсэг маань ажилласан, маш сайн ажилласан. Өргөн бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсэг гарсан. Ингээд үндсэндээ гурван 7 хоног. Өнөөдөр ингээд 3 хоногийн завсарлага авах юм бол дөрвөн 7 хоног Ардчилсан намын бүлгийг хүндэтгээд бид нар, 60 хуудас зарчмын зөрүүтэй санал гарчихсан байгаа. Энэ бүхэн дээр манай ажлын хэсгийн гишүүд, Ардчилсан намын гишүүд, бас хүмүүс танилцаж байгаа байх. Асуудлууд байвал ярих нээлттэй болж байгаа байх аа. Харьцангуй судлах, танилцах, хэлэлцэх бололцоо боломжоор, завсарлагын хугацаа уул нь 5 хоног. Гэтэл үүнээс өөр хүндэтгэн үзэх шалтгаанаас болж сарын хугацаа болж байна шүү.

Өнөөдөр чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу даргын зөвлөлөөр шийдэж Даваа гарагт Байнгын хороо хуралдаж байгаа. Энэ бас хуулиар нээлттэй байж байгаа. Энийг хууль зөрчсөн ямар нэгэн асуудал байхгүй гэдгийг бас зөв ойлгоорой. Тэгээд, заавал завсарлага авч оны дараа хэлэлцье гэж хүсэлт гаргаад байх шиг байна. Оны дараа ямар нэгэн элдэв шалтаг тайлбар байхгүй энэ асуудлаа хэлэлцээд явъя. Тэгээд 3 хоногийн завсарлага өгье. Хамгийн гол нь үүнээс хойш ямар нэгэн шалтаг тайлбар бас битгий хэлээрэй. Тэгээд асуудалдаа бүгдээрээ оруулаад хэлэлцье. 3 хоногийн завсарлага өглөө. Шинэ оны бэлэг боллоо шүү. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ